



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/51

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал, амралтын  
газрын үйл ажиллагаа  
эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй  
болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандартын шаардлагыг хангасан, тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандартын шаардлагыг хангасан, тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан, аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS 6043:2009” стандартын шаардлагыг хангасан, тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид жуулчны баазын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Дөлгөөн нуур ХХК-ийн “Дөлгөөн нуур” зочид буудлын 18/281, Стар интер трейд ХХК-ийн “Их бүрд” зочид буудлын 18/272, Тайж өргөө од ХХК-ийн “Тайж” зочид буудлын 18/251, Наран саран ХХК-ийн “Рич”

1150500254




зочид буудлын 18/229, Монхурд ХХК-ийн “555” зочид буудлын 18/99, Жэй ти жэй ХХК-ийн “Амарбаясгалант” зочид буудлын 18/266, Зол халиун соронз ХХК-ийн “Соронз” зочид буудлын 18/265, Нот трейд ХХК-ийн “Нарлаг” дэн буудлын 18/286, Алтан долгио ХХК-ийн “Гүн молор” дэн буудлын 18/285, Улаан царам ХХК-ийн “Эм жи” дэн буудлын 18/112, ЭСДЛ ХХК-ийн “Цэцээ гүн” амралтын газрын 18/248 гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

5. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг үйлчилгээний чанар стандарт хариуцсан мэргэжилтэн /Ч.Энх-Отгон /-д үүрэг болгосугай.

7. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг тухайн байгууллагаас хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батцож/-д даалгасугай.

ДАРГА *D. Balm* Д.БАТСҮХ



5284325 СБТ-8926 1118263502



Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2019 оны 06  
сарын 25 өдрийн А/51 дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт

5284325 CST-8976 1118263502

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2019.06.25

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Дөлгөөн нуур ХХК	2088444	Дөлгөөн нуур	СБД-ийн, 9-р хороо, Их тойруу 38
2	Стар интер трейд ХХК	2714388	Их бүрд	ЧД-ийн, 9-р хороо, Энэбишийн өргөн чөлөө 43 тоот
3	Тайж өргөө од ХХК	6313841	Тайж	БЗД-ийн, 7-р хороо, Доржийн 3н тоот
4	Наран саран ХХК	5007909	Рич	ЧД-ийн, 6-р хороо, 6-р хороолол, Их тойруу 27
5	Монхурд ХХК	2068974	555	СХД-ийн, 18-р хороо, Энхтайваны өргөн чөлөө
6	Жэй ти жэй ХХК	6231217	Амарбаясгала нт	СБД-ийн, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 15
7	Зол халиун соронз ХХК	4552318	Соронз	БД-ийн, 4-р хороо, Жаргалантын 1-1

-ooOoo-



Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын, 2019 оны 06  
сарын 25 өдрийн А/51 дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт

5234325 CST 8936 1115263502

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2019.06.25


Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Нот трейд ХХК	2733129	Нарлаг	СБД-ийн, 8-р хорооны 33-2 тоот
2	Алтан долгио ХХК	2672103	Гүн молор	БЗД-ийн, 1-р хороо, Токиогийн гудамж
3	Улаан царам ХХК	2564246	Эм жи	ХУД-ийн, 10-р хороо, Буянт ухаа 64-1
4	Алс тэртээ ХХК	5392098	Топаз	БЗД-ийн, 13-р хороо, Дүүргийн 4-177 тоот
5	Гурван мөнх оргил ХХК	5244293	Мая хаус	СБД-ийн, 19-р хороо, Баянбулаг 4-411 тоот
6	Хийморийн нөмөр ХХК	5494052	Эд	БЗД-ийн, 2-р хороо, АОС гудамж 46 тоот

-ooOoo-



Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2019 оны 06  
сарын 25 өдрийн А/51 дугаар  
тушаалын гурвдугаар хавсралт



АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2019.06.25

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	ЭСДЛ ХХК	5131111	Цэцээ гүн	БЗД-ийн, 11-р хороо, Төр хурахын ам

-ooOoo-